



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Энхбүрд Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/03/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот

2024 оны 03 дугаар сар 15

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК
Захирал Г.Саранчимэг
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com
Аудитор: О.Мандах
Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН,.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4.АУДИТЫН ТАЙЛАН.....	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	14
5.1 Төлбөрийн акт.....	14
5.2 Албан шаардлага.....	15
6.АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024.03.15 № 2/88

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор сумын Энхбүрд Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баянхонгор сумын Энхбүрд Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/212 дугаар тушаалаар батлагдсан Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрмийг мөрдлөг болгон ажилладаг. Нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан төв нь дараах зохион байгуулалттай байна. Үүнд:

- Тухайн төвд ажиллаж байгаа эмч, эмнэлэгийн мэрэгжилтний 70-аас доошгүй хувь нь нөхөрлөлийн гишүүн байна
- Төвийн удирдлага нь нөхөрлөлийн бүх гишүүдийн хурал байна

гэж заасан ба төвийн хөрөнгө хэрхэн зарцуулах талаар нөхөрлөлийн гишүүдийн хурлаар шийдвэрлэдэг байна.

2023 онд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах Эрүүл мэндийн хөгжлийн төвийн магадлан итгэмжлэлийн шалгалтанд орж үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 4 жилийн хугацаатай сунгуулсан байна. Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

5020331

Тайлант онд 477,129.9 мянган төгрөгийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж Эрүүл мэндийн даатгалын сангаас 435,539.1 мянган төгрөгийн санхүүжилт авч 41,590.7 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

Аудитын гол асуудал

Өрхийн эрүүл мэндийн төв нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж үйлчилгээг нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар санхүүждэг ба өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж үйлчилгээ нь тохиолдолд суурилсан төлбөрөөр санхүүждэг. Тайлант хугацаанд цахим төлбөрийн /е-баримт/ баримтгүй ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан, хавсран ажилласан цалинг илүү олгосон байна

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баянхонгор сумын Энхбүрд Өрхийн эрүүл мэндийн төв нь Аймгийн засаг дарга, Эрүүл мэндийн газрын даргатай гурвалсан гэрээ байгуулж 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 92,2 хувьтай дүгнэсэн байна.

Баянхонгор сумын Энхбүрд Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
		2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
А	Б	1	2
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	408,396.64	136,338.08
1.1.3	Байгууллагаас авах авлага	5,000,000.00	0.00
1.1.4	ЭМД-ийн авлага	0.00	41,590,738.00
1.1.6	Бараа материал	21,036,384.25	17,209,197.00
0	Эргэлтийн хөрөнгийн дүн	26,444,780.89	58,936,273.08
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	237,995,316.54	243,699,347.75
1.2.2	Биет бус хөрөнгө	7,592,000.00	7,509,500.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	245,587,316.54	251,208,847.75
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	272,032,097.43	310,145,120.83
2.3	2. Эзэмшигчийн өмч	262,083,121.21	268,271,029.21
2.3.1	Өмч: -Төрийн	262,083,121.21	268,271,029.21
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	9,681,147.20	9,681,147.20
2.3.8	Эздийн өмч бусад хэсэг	7,427,000.00	7,427,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-7,159,170.98	24,765,944.42
2.3.11	Эздийн өмчийн дүн	272,032,097.43	310,145,120.83
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	272,032,097.43	310,145,120.83

2.2 Аудит хийсэн орлогын тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	385,764,927.04	485,481,103.86
10	Ерөнхий ба удирдлагын зардал	391,543,272.63	453,555,988.46
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-5,778,345.59	31,925,115.40
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-5,778,345.59	31,925,115.40
24	Орлогын нийт дүн	-5,778,345.59	31,925,115.40

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31 үлдэгдэл	258,815,467.92	9,681,147.20	7,427,000.00	(1,380,825.39)	274,542,789.73
2	Тайлант үеийн цэвэр ашиг				-5,778,345.59	(5,778,345.59)
3	Өмчид гарсан өөрчлөлт	3,267,653.29				3,267,653.29
4	Тайлант үеийн үр дүн	-				-
5	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	262,083,121.21	9,681,147.20	7,427,000.00	-7,159,170.98	272,032,097.43
6	Тайлант үеийн цэвэр ашиг				31,925,115.40	31,925,115.40
7	Өмчид гарсан өөрчлөлт	6,187,908.00				6,187,908.00
8	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	268,271,029.21	9,681,147.20	7,427,000.00	24,765,944.42	310,145,120.83

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	367,451,350.00	444,086,042.86
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	95,094,510.00	114,655,300.00
	Татаас, санхүүжилтийн орлого	271,006,840.00	320,883,861.28
	Бусад мөнгөн орлого	1,350,000.00	8,546,881.58
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	322,569,945.61	420,454,551.42
	Ажилчдад төлсөн	159,267,560.00	179,640,523.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	48,879,800.00	55,703,416.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	57,218,228.00	86,007,505.00
	Ашиглалтын зардалд төлсөн /холбоо, бичиг хэргийн зардал/	15,562,176.00	20,442,004.00
	Түлш,шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,974,000.00	9,561,100.00
	Даатгалын байгууллагад төлсөн	248,500.00	
	Бусад мөнгөн зарлага	36,419,681.61	69,100,003.42
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-109,385.61	-272,058.56
2	Хөрөнгө, оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	44,990,790.00	23,903,550.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	44,990,790.00	23,903,550.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-109,385.61	-272,058.56
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	517,782.25	408,396.64
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	408,396.64	136,338.08

2.5 Зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр

д/д	Зардлын нэр	2023 оны төлөвлөгөө	2023 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,841,699.0	231,841,699.0	0.0	100.0
2	Үндсэн цалин	179,387,149.0	179,387,149.0	0.0	100.0
3	Үр дүнгийн урамшуулал	19,668,945.0	19,668,945.0	0.0	100.0
4	ЭМДаатгалын урамшуулал	32,785,605.0	32,785,605.0	0.0	100.0
5	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,715,631.0	29,715,631.0	0.0	100.0
6	Цахилгааны зардал	9,262,067.0	9,262,067.0	0.0	100.0
7	Цэвэр бохир усны зардал	373,288.0	373,288.0	0.0	100.0
8	бичиг хэрэг	8,993,775.0	8,993,775.0	0.0	100.0
9	Шуудан холбоо	1,812,874.0	1,812,874.0	0.0	100.0
10	Шатахуун	5,120,600.0	5,120,600.0	0.0	100.0
11	Эм боох материал	111,587,591.75	96,925,380.25	14,662,211.5	86.9
12	Сэлбэг	4,440,500.0	4,440,500.0	0.0	100.0
13	албан томилолт	3,693,400.0	3,693,400.0	0.0	100.0
14	Бараа үйлчилгээний бусад зардал	71,157,374.2	61,157,374.2	10,000,000.0	85.9
15	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	220,000.0	220,000.0	0.0	100.0
16	Татварын өмнөх ашиг		31,925,115.4	-31,925,115.4	
17	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	478,218,800.0	485,481,103.86	7,262,303.9	101.5
18	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	478,218,800.00	485,481,103.86	7,262,303.86	101.5
19	Нэг иргэнээс санхүүжих	321,972,800.00	324,975,599.28	-1,088,938.72	99.7
20	Үндсэн тусламж үйлчилгээнээс	156,246,000.0	152,154,300.0	0.0	100.0
21	Үйл ажиллагааны орлогоос		3,221,919.58	3,221,919.6	
22	Үнэ төлбөргүй орлого		5,129,323.0	5,129,323.0	
23	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
24	АЖИЛЛАГСДЫН ТОО	11	11		100.0
25	Дарга	1.0	1.0		100.0
26	Их эмч	3.0	3.0		100.0
27	Сувилагч	5.0	5.0		100.0
28	НЭМА	1.0	1.0		100.0
29	Үйлчлэх ажилтан	1.0	1.0		100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын Энхбүрд Өрхийн эрүүл мэндийн төв нь Баянхонгор сумын Цахир 7-р баг, Есөнбулаг 9-р багийн хүн амд Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх чиг үүргийн дагуу тайлант онд “Эмнэлгийн ажилтны ёс зүйг эрхэмлэн дээдэлж, өрх иргэн бүрт эмнэлгийн анхан шатны тусламжийг сэтгэл ханамжтай, тэгш шударга хүртээмжтэй ур чадварын өндөр түвшинд шуурхай хүргэх” гэсэн зорилго тавин

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах
- Иргэдэд эрүүл аж төрх дадал хэвшил олгох.
- Үйлчлүүлэгчид ээлтэй орчин бүрдүүлэх 3 зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Баянхонгор сумын Энхбүрд Өрхийн эрүүл мэндийн төв нь дарга 1, их эмч 3, өрхийн сувилагч 2, дүн бүртгэгч 1, вакцинолог сувилагч 1, эх баригч 1, сэргээн засах эмчилгээний сувилагч 1, НЭМА 1, үйлчлэгч 1, нягтлан бодогч 0.5 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант онд нийт үзлэг 8730, урьдчилан сэргийлэх үзлэг 5220, идэвхтэй хяналт 1460, гэрийн дуудлага 70, гэрийн идэвхтэй хяналт 1005, жирэмсний хяналт 116 бүртгэгдсэн өвчлөл 859 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

2023 онд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах Эрүүл мэндийн хөгжлийн төвийн магадлан итгэмжлэлийн шалгалтад орж үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 4 жилийн хугацаатай сунгуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Нөхөрлөлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийгмийн даатгалын тухай, болон Татварын багц хуулиудыг мөрдөж ӨЭМТ-ийн бүтэц үйл ажиллагааны MNS-52:92 2017 стандарт болон Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/212 дугаар тушаалаар батлагдсан Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрмийг мөрдлөг болгон ажилладаг. Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх өрхийн эрүүл мэндийн баг нь нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд байна гэж тус үлгэрчилсэн дүрэмд заасан байна. Нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан төв нь дараах зохион байгуулалттай байна. Үүнд:

Тухайн төвд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтний 70 –аас доошгүй хувь нь нөхөрлөлийн гишүүн байна. Төвийн удирдлага нь нөхөрлөлийн бүх гишүүдийн хурал байна гэж заасан ба төвийн хөрөнгө хэрхэн зарцуулах талаар нөхөрлөлийн гишүүдийн хурлаар шийдвэрлэдэг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолыг чиглэл болгон ажилчдын цалинг нэмэгдүүлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Энхбүрд Өрхийн Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй мөрдөж 2008 онд ММНБИНститут, Эрүүл мэндийн яам хамтран боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын Энхбүрд Өрхийн эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,113.0 мянган төгрөгөөр буюу 14.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	408.4	136.3	-272.10
Авлага	5000	0	-5,000.00
борлуулалтын авлага		41590.7	41,590.70

Баянхонгор сумын Энхбүрд өрхийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Бараа материал	21,036.4	17209.2	-3,827.20
Үндсэн хөрөнгө	351,006.80	381,098.20	30,091.40
хуримтлагдсан элэгдэл	-105,419.50	-129,889.30	-24,469.80
Нийт хөрөнгө	272,032.10	310,145.10	38,113.00
Өр төлбөр			0.00
/Эздийн өмч/	262,083.10	268,271.00	6,187.90
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	272,032.10	310,145.10	38,113.00

Эх сурвалж: Баянхонгор сумын Энхбүрд өрхийн Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор сумын Энхбүрд Өрхийн эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан данс нь авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд оны эхэнд 408.4 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 136.3 мянган төгрөгийн өмнөх оноос 272.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд 156,094.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч үйл ажиллагаанд 159,922.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж бараа материалын үлдэгдэл 3,827.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд 2022 оны 5000.0 мянган төгрөгийн авлага барагдуулж, ЭМДаатгалын сангаас авах 41,590.7 мянган төгрөгийн авлага нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 30,091.4 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн нь өөрийн хөрөнгөөр 23,903.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан. Аймгийн ИТХ-н хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 17/65 тогтоол, Аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн “Тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл хуваарилах тухай” А/69 дүгээр тогтоолоор үнэ төлбөргүй 6,187.9 мянган төгрөгийн хөрөнгө нийт 30,091.4 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Эзэмшигчийн өмч нь дансны үлдэгдэл үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 6,187.9 мянган төгрөгөөр нэмэгдэж 268,271.0 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаарх эздийн өмчийн дүн өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 31,925.1 мянган төгрөгөөр, өмчид гарсан өөрчлөлт 6,187.9 мянган төгрөгөөр нэмэгдэж 310,145.1 мянган төгрөг болсон байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Өрхийн эрүүл мэндийн төв нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж үйлчилгээг нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар санхүүждэг ба өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж үйлчилгээ нь тохиолдолд суурилсан төлбөрөөр санхүүждэг.

№	Хөтөлбөр, арга хэмжээ	ЭМД-ын сангаас авах гүйцэтгэл	ЭМД-ын сангаас олгосон дүн	Зөрүү
1	Нэг иргэнээр тооцсон нормативаар	324,975.6	320,883.9	4,091.7
2	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	152,154.3	114,655.3	37,499.0
		477,129.9	435,539.2	41,590.7

Нэг иргэнд ногдох санхүүжилт 2022 онд 271,006.8 мянган төгрөг 2023 онд 324,975.6 мянган төгрөг өмнөх оноос 53,968.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг багийн иргэдэд үзүүлдэг 4 багц тусламж үйлчилгээ 2022 онд 94,094.5 мянган төгрөг, 2023 онд 152,154.3 мянган төгрөг болж 58,059.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Тусламж үйлчилгээг гүйцэтгэлээр үзүүлдэг болсноор иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээ сайжирч өрхийн эрүүл мэндийн орлого нэмэгдсэн байна.

Тайлант онд ЭМДаатгалын санхүүжилтээр 477,129.9 мянган төгрөг үйл ажиллагааны орлого 8351.2 мянган төгрөг нийт 485,481.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 453,555.9 мянган төгрөгийн зардал гарган 31,925.1 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор сумын Энхбүрд Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О. Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Энхбүрд өрхийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 2 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Энхбүрд өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга Э.Гүнжинлхам, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Эрдэмээ нар зурж нар ажиллажээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 391,543.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,873.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын 75 хувиар буюу 5,227.6 мянган төгрөгөөр тогтоосон гүйцэтгэлийн түвшинд материаллаг байдлыг шинэчлэх шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээллийг улирал бүр бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг түүврээр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор М. Алтантуяа гүйцэтгэж, 215.0 мянган төгрөгийн төлбөрийн акт 1, 3000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	215.0	1	215.0	100
Зөвлөмж	1	3000.0	1	3000.0	100
Нийт дүн	2	3215.0	2	3215.0	100

Аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж төлбөрийн актыг бүрэн барагдуулсан байна

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 15–ны өдрийн А/212 тушаалын хавсралт “Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 1.3 “Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх өрхийн эрүүл мэндийн төвийн баг нь нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд байна” гэсэн ззалтын дагуу байгуулагдсан хуулийн этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэнэ” гэсэн хуулийн заалттай нийцэхгүй байна.
2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 42 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батласан “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх” гэрээний загварт орон нутгийн өмчийг эзэмшүүлэх, ашиглах, түрээслэх заалт нь тодорхой бус, Аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн даргатай байгуулсан “Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээ”-ний 4.1.4 Төвийн ашиглаж буй орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтанд тавих хяналт, ... 8.1 Төв нь Аймгийн өмчийн газартай “Өмч эзэмших гэрээ” байгуулана, 8.2 Төвд ашиглагдаж буй өмч хөрөнгийн тооллогыг жилд 2 удаа хийнэ гэсэн заалтууд нь хоорондоо зөрчилтэй байна.
3. Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг 1 иргэнд ноогдох тарифаар тухайн багт харьяалалтай иргэдийн тоогоор төлөвлөдөг боловч зардлыг төлөвлөөгүй байгаа нь зардалд хяналт тавих боломжгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 37,105.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

-Тайлант хугацаанд цалингаас даатгуулагчаас суутгасан 25,987,8 төгрөгийг үр дүнгийн тайланд ндш-ийн зардлаар тайлагнаж зардал нэмэгдүүлсэн.

-Цалингийн зардлаар тооцож үйл ажиллагааны зардлаар тайлагнаагүй 11,117.7 төгрөгийг санхүүгийн тайланд цалин, ндш-ийн өглөгөөр тусгасан.

Аудитаар 1,212.3 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрсэнд 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1.Илрүүлэлт: Ажил хавсран ажиллуулах нөхөрлөлийн гишүүдийн тогтоол шийдвэргүйгээр 2023 оны 8 дугаар сараас 12 дугаар сар хүртэлх хугацаанд Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Э.Гүнжинлхамд 677.8 мянга, их эмч Н.Онцгэрэлд 534.5 мянган төгрөгийн цалин илүү олгосон.

Энэ нь Нөхөрлөлийн туай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 “Удирдах эрх бүхий гишүүд олонхийн саналаар шийдвэр гаргах бөгөөд шийдвэртэй холбогдон үүсэн хариуцлагыг хамтран хариуцна”, Эрүүл мэндийн сайдын “Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм батлах тухай” 2021 оны А/212 тушаалын 3.3.2 “Төвийн удирдлага нь нөхөрлөлийн бүх гишүүдийн хурал” гэсэн заалтуудыг зөрчин нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Ажил хавсран ажиллуулах нөхөрлөлийн гишүүдийн тогтоол шийдвэргүйгээр илүү олгосон цалинг Өрхийн эрүүл мэндийн даргаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Илрүүлэлт: Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 27,330.7 мянган төгрөгийн гүйлгээнээс аудитын явцад 25,752.5 мянган төгрөгийн гүйлгээг цахим төлбөрийн /е баримт/ баримтад нөхөн шивүүлж, 2,578.2 мянган төгрөгийн гүйлгээ цахим төлбөрийн баримтад бүртгэгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн, үнэлгээ батламж мэдэгдлийг хангаагүй байна байна.

Шийдвэрлэсэн нь: Аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн е баримтаар баталгаажуулж анхан шатны баримтыг бүрдүүлж гүйлгээ хийж байх албан шаардлага өгөв.

Дээрх төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Баянхонгор сумын Энхбүрд өрхийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

цалингаас даатгуулагчаас суутгасан 25,987,8 төгрөгийг үр дүнгийн тайланд ндш-ийн зардлаар тайлагнасан.	1				1	25987.8	1	25987.8				
Цалингийн зардлаар тооцож үйл ажиллагааны зардлаар тайлагнаагүй 11,117.7 төгрөгийг санхүүгийн тайланд цалин, ндш-ийн өглөгөөр тусгасан.	1				1	11,117.7	1	11,117.7				
Дүн	2	37,105.5			2	37,105.5	2	37,105.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ажил хавсран ажиллуулах нөхөрлөлийн гишүүдийн тогтоол шийдвэргүйгээр 1212,3 мянган төгрөгийн цалин илүү олгосон.	1	1,212.3	1	1,212.3								
25,752.5 мянган төгрөгийн гүйлгээг цахим төлбөрийн /е баримт/ баримтад нөхөн шивж, 2,578.2 мянган төгрөгийн гүйлгээ цахим төлбөрийн баримтгүй	1				1							
Дүн	2	1,212.3	1	1,212.3								



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 921/14210573/670А-2024
/03/2024-СТН-ОНА

Номгон

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Энхбүрд Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажил хавсран ажиллуулах нөхөрлөлийн гишүүдийн тогтоол шийдвэргүйгээр 2 ажилтанд 1,212,294 төгрөгийн цалин илүү олгосон байна.

Энэ нь Нөхөрлөлийн туай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 “Удирдах эрх бүхий гишүүд олонхийн саналаар шийдвэр гаргах бөгөөд шийдвэртэй холбогдон үүсэн хариуцлагыг хамтран хариуцна”, Эрүүл мэндийн сайдын “Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм батлах тухай” 2021 оны А/212 тушаалын 3.3.2 “Төвийн удирдлага нь нөхөрлөлийн бүх гишүүдийн хурал” 3.3.3 гэсэн заалтыг зөрчин нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 дахь “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон ” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Хавсран ажилласан цалинг илүү тооцож олгосон 1,212,294 /Нэг сая хоёр зуун арван хоёр мянга хоёр зуун ерэн дөрвөн/ төгрөгийг төсвийн захирагчаар төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.


5050340

2.Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор сумын Энхбүрд Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Э. Гүнжинлхам, нягтлан бодогч Д.Эрдэмээ нарт хариуцуулав¹.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТОР:  О.МАНДАХ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 222/НХА/0573/БНА-2024
103/НА-СТА-ОНА

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Энхбүрд Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 27,330.7 мянган төгрөгийн гүйлгээнээс аудитын явцад 25,752.5 мянган төгрөгийн гүйлгээг цахим төлбөрийн /е баримт/ баримтад нөхөн шивүүлж, 2,578.2 мянган төгрөгийн гүйлгээ цахим төлбөрийн баримтад бүртгэгдээгүй е баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтыг зөрчсөн, үнэлгээ батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.1 дэх "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль

5040671

тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй; гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг арилган биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор сумын Энхбүрд Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Э.Гүнжинлхам, нягтлан бодогч Д.Эрдэмээ нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР:  О.МАНДАХ

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно